

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.05.27

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

2024 он 05-р сарын 27

- AIA Group Хятад дахь үл хөдлөх худалдан авч оффисын барилгуудын тоогоо нэмж байна.
- Evergrande Group2-ын цахилгаан автомашины нэгж NEV компани худалдан авагчтай боллоо.
- Өнөөдөр буюу Даваа гарагт дурсгалын өдөр (Memorial Day) тохиож байгаа тул хөрөнгийн зах зээл амарна.
- Пүрэв гарагт S&P500 индексд багтдаг компаниудын 90 орчим хувь нь уналттай арилжаалагдсан.
- Инфляцийг өдөөж байгаа гол хүчин зүйл нь үйлчилгээ бус харин үйлдвэрлэл байна.

|             |           |
|-------------|-----------|
| Dow Jones   | 39,069.59 |
| S&P 500     | 5,304.72  |
| Nasdaq      | 16,920.79 |
| DAX         | 18,694.42 |
| FTSE 100    | 8,317.59  |
| S&P/ASX 200 | 7,727.6   |
| HANG SENG   | 18,608.94 |

АНУ-ын индексийн өгөөж

| Индекс                        | Өдрийн | Долоо хоног | Сар   | Жилийн эхнээс | Жил    | 3 жил  |
|-------------------------------|--------|-------------|-------|---------------|--------|--------|
| Dow Jones                     | 0.01%  | -1.85%      | 2.17% | 3.66%         | 18.06% | 13.15% |
| S&P 500                       | 0.70%  | -0.06%      | 4.01% | 11.21%        | 26.14% | 26.18% |
| Nasdaq                        | 1.10%  | 0.75%       | 6.23% | 12.72%        | 30.40% | 23.07% |
| 2024 оны 05 сарын 27-ны 11:00 |        |             |       |               |        |        |



Европын индексийн өгөөж

| Индекс                        | Өдрийн | Долоо хоног | Сар   | Жилийн эхнээс | Жил    | 3 жил  |
|-------------------------------|--------|-------------|-------|---------------|--------|--------|
| DAX                           | 0.02%  | -0.40%      | 2.94% | 11.60%        | 16.96% | 20.45% |
| FTSE 100                      | -0.26% | -1.27%      | 2.18% | 7.56%         | 9.05%  | 18.44% |
| 2024 оны 05 сарын 27-ны 11:00 |        |             |       |               |        |        |



Ази Номхон далайн индексийн өгөөж

| Индекс                        | Өдрийн | Долоо хоног | Сар   | Жилийн эхнээс | Жил    | 3 жил   |
|-------------------------------|--------|-------------|-------|---------------|--------|---------|
| S&P/ASX 200                   | 0.71%  | -1.03%      | 2.73% | 2.53%         | 8.78%  | 8.40%   |
| Hang Seng                     | 0.31%  | -5.01%      | 5.68% | 9.42%         | -0.50% | -35.95% |
| 2024 оны 05 сарын 27-ны 11:00 |        |             |       |               |        |         |





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

АНУ-ын S&P500 болон Nasdaq100 индексүүд оройн цэгүүдээ дахин шинэчилсэн бол Dow Jones Industrial Average индекс -2.33 хувийн уналттай байлаа. Өнөөдөр буюу Даваа гарагт дурсгалын өдөр (Memorial Day) тохиож байгаа тул хөрөнгийн зах зээл амарна.

Өнгөрсөн долоо хоногт олны анхаарлын төвд байсан үйл явдал бол Nvidia компанийн нэгдүгээр улирлын тайлан байлаа. Компанийн нэгдүгээр улиралд 2.6 тэрбумын орлого, 6.12 ам.долларын нэгж хувьцаанд ногдох ашигтай ажиллаж шинжээчдийн хүлээлтийг дахин давж чадлаа. Ингэснээр тус компанийн хувьцаа 16 гаруй хувиар өссөн.

Гэсэн хэдий ч тус сайн мэдээ нь зах зээлийг тийм их өсгөж чадсангүй. Nvidia компанийн гүйцэтгэл сайн байсан ч Пүрэв гарагт S&P500 индексд багтдаг компаниудын 90 орчим хувь нь уналттай арилжаалагдсан.

Учир нь инфляцийн мэдээлэл хөрөнгө оруулагчдын санааг зовоосон бололтой. S&P Global-ын ахлах эдийн засагч хэлэхдээ борлуулалтын үнийн инфляц өсөж байгаа бөгөөд сонирхолтой нь инфляцийн гол түлхэц нь үйлчилгээ гэхээсээ илүү үйлдвэрлэлээс ирж байгаа нь одоо зардал, борлуулалтын үнийн инфляцийн түвшин бага зэрэг өссөн гэсэн үг юм. ХНС-ын зорилтот 2%-д хэзээ хүрэх нь одоо ч гэсэн тодорхойгүй мэт санагдаж байна хэмээжээ.

### График 1: АНУ-ын S&P500 индекс ба техник шинжилгээ



Техник шинжилгээний үүднээс энэ сарын дундаас ханшийг хүчтэй эсэргүүцэж байсан 5349 түвшин Nvidia компанийн тайлантай зэрэгцэн дээшээ задарсан ч хүчтэй үргэлжилж чадалгүй 5306 дээр байсан хамгийн сүүлийн өндөр ёроолыг давж унасан учир богино хугацааны чиг хандлага уналттай арилжаалагдаж эхэллээ. Энэ долоо хоногт АНУ-ын S&P500 индекс өсөлтөөр 5342-5352 хүрээд уналтаар өмнөх болох 5273 гэсэн ханшийг шалгах боломжтой байна.





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

БНХАУ мөнгөний бодлогоо хэвэнд нь үлдээн нэг болон таван жилийн зээлийн хүүг 3.45 болон 3.95 хувь дээр тогтоосон байна. Энэ жилийн хувьд зарим шинжээчид сул хүүгийн бодлогыг хүлээж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан банкны нөөцийн шаардлагыг ч адил сулруулах болов уу гэсэн хүлээлттэй байна.

Тус улсын үл хөдлөх салбарын уналт үргэлжилсээр байгаа хэдий ч Азийн томоохон даатгалтын компани болох AIA Group Эх газрын Хятад улс дахь офисын барилгуудын тоог нэмэгдүүлж байна. AIA 2022 оны сүүлээс эхлэн Бээжин болон Шанхай хотуудад үл хөдлөх худалдан авч буй нь тус компанийн тогтвортой мөнгөн урсгал болон өргөжиж буй бизнес үйл ажиллагаатай холбоотой. AIA Group-ын ТУЗ-ын дарга Edmund Tse Sze-wing “одоогоор үл хөдлөхийн үнэ ханш тохиромжтой цэгтээ хүрээд байгаа бөгөөд бидний тогтвортой үйл ажиллагааны мөнгөн урсгалаар баталгаажсан хөрөнгө оруулалт хийхэд тааламжтай нөхцөл байдал үүссэн байна” хэмээн тэмдэглэжээ.

### График 2: AIA Group хувьцааны ханшийн график ба техник шинжилгээ



Түүнчлэн, дампуурлаа зарласан Хятад үл хөдлөхийн Evergrande компанийн цахилгаан автомашин үйлдвэрлэлийн нэгж болох New Energy Vehicle (NEV)-ыг худалдан авагчтай болсон байна. Тус хэлцлийн эхний шатанд нэр нь ил болоогүй худалдан авагч Evergrande NEV-ийн 29 хувийг худалдан авах бөгөөд нэмэлтээр 29.5 хувийг авах сонголттой байхаар байна. Тус цахилгаан автомашин үйлдвэрлэгч 2023 оны сүүлийн байдлаар нийт 1700 Hengchi загварын автомашин үйлдвэрлээд байгаа бөгөөд өнгөрсөн жилийг 12 тэрбум юанийн алдагдалтай хаагаад байна.

Evergrande NEV компанийн хувьцааны арилжаа 5-р сарын 17-нд зогсоогдсон бөгөөд тухайн үеийн үнэлгээ нь 528 сая ам.доллар байсан бөгөөд арилжаа 5-р сарын 27-нд дахин нэгдэх үед хувьцааны ханш 90 гаруй хувь өсжээ.

ТАЙЛАНГИЙН ХУАНЛИ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

| E EARNINGS WHISPERS   |  | Most Anticipated Earnings Releases<br>for the week beginning<br>May 20, 2024                      |  |   |   |  |   |   |  |
|---|--|---|--|---|---|--|---|---|--|
| Monday  |  | Tuesday   |  | Wednesday   |   | Thursday   |   | Friday  |  |
| Before Open   | After Close  | Before Open   | After Close  | Before Open   | After Close   | Before Open  | After Close   | Before Open   |  |
|  理想                    |  paloalto     |  ZIM             |  Toll Brothers    |  TARGET                      |  NVIDIA            |  B's             |  DECKERS     |  Booz   Allen   Hamilton |  |
|  WUX                   |  zoom         |  LOWE'S          |  MODINE           |  PDD                         |  snowflake         |  TD Bank         |  intuit      |  MLAB                    |  |
|  Global                |  Trip.com     |  macy's          |  Viasat           |  Pinduoduo                   |  elf               |  RALPH LAUREN    |  ROSS        |  MesaLabs                |  |
|  compugen              |  James Hardie |  AutoZone        |  URBAN OUTFITTERS |  TJX                         |  synopsys          |  endava          |  workday     |   |  |
|  nexxen                |  Nordson      |  Eagle Materials |  SKYLINE CHAMPION |  ANALOG DEVICES              |  CORPORATION       |  maxeon          |  SILVERCORP  |   |  |
|  360                   |  KEYSIGHT     |  XPENG           |  alvotech         |  DORIAN LPG                  |  STAR BULK         |  Medtronic       |  cavco       |   |  |
|  ARQIT                 |  tuya         |  PHGE            |  XP inc.          |  DYCOM                       |  SQM               |  Polestar        |  Woodmark    |   |  |
|  RYANAIR               |  TRANSCAT     |  PropertyGuru    |  |  WILLIAMS-SONOMA             |  LiveRamp          |  NetEase Games   |  emeran      |   |  |
|  Star Equity Holdings |  BEAM        |  YMM             |  |  walkme                      |  GRUPO SUPERVIELLE |  TITAN MACHINERY |  STEPSTONE  |   |  |
|  搜狐                  |  HESAI      |  满帮             |  |  petco                     |  agora           |  贝壳            |  LIONSGATE |   |  |
| http://eps.sh/cal   |  |  金融壹账通         |  |  THE HEALTH & WELLNESS CO. |   |  |   |   |  |
| © 2024 Earnings Whispers  |  |   |  |   |   |  |   |   |  |

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

| E EARNINGS WHISPERS   |             | Most Anticipated Earnings Releases   |  |  |  |   |   |             |
|---|-------------|--|--|--|--|---|---|-------------|
|   |             | for the week beginning<br>May 27, 2024   |  |  |  |   |   |             |
| Monday  |             | Tuesday  |  | Wednesday  |  | Thursday  |   | Friday      |
| Before Open   | After Close | Before Open  | After Close  | Before Open  | After Close  | Before Open   | After Close   | Before Open |
|  |             | <br> | <br> | <br><br><br> | <br><br><br><br><br><br><br><br><br> | <br><br><br><br><br><br><br><br><br><br> |  |             |
| <a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>                                   |             |  |  |  |  |   |   |             |